

## СУВДАН ЭРХИ

## «ГУРВАН УЛСЫН ҮЛГЭР»

Эртний Хятадын уран зохиолоос хамгийн алдартайн нэг нь энэхүү «Гурван улсын үлгэр» мөн. Христосын он тооллын эхэн үед оршин тогтнож байсан Шу, У, Вэй гурван улсын үеийн бодит түүхэн үйл явдлыг хятадын авьяас билэгт ард түмэн ам дамжуулан баяжуулж ирсэнийг Тан улсын үед авьяаслаг бичгийн хүн Ло Гуань-жүн эмхэтгэн, түүхэн судрын хэлхээсийн дагуу найруулахдаа эрин зууны уртад балран дарагдашгүй гайхамшигт туульс болгосон билээ. Дөрвөн дэвтэр, нэг зуун хорин бүлэг энэ аварга туульсыг манай залуу үеийнхэн шимтэн унших аваас зөвхөн хятадын ард түмний сонгодог өв төдийгүй хүн төрөлхтний бүтээсэн оргил соёлын нэг гэдгийг ухаарч бишрэн баясах буй заа.

Бид энэ дугаартаа уг туульсын нэгэн дуслыг нийтлэв. Өвөр Монголын эрдэмтэн зохиолч Тэмэгэтийн орчуулгаар 1950-иад онд Хөх хотноо хэвлэгдсэн эхээс авсан буй.

Т. МАНДИР

«Гурван улсын үлгэр»-ийн 79-р бүлгээс

...Ах нь дүүгээ цухалдуулж

Цао Жи шүлэг шүлэглэсэн...

... (Цао Цаог үхсэний дараа) ахмад хүү Цао Пэй залгамжилж Вэй вангийн сууринд суугаад... их бага түшмэдийг цөм шагнаж дэвшүүлсэн хойно... Хуа Синь өгүүллүүн:

— Линьжихөү (хэргэм) Цао Жи... суусаар үзэж бэлбэсрэлд ирэхгүй тул ял асуугаар одвоос зохино гэсэнд Цао Пэй үгийг дагаж хүн зарж ял асуугаар илгээв. Нэг өдөр өнгөрөөд элч ирж өгүүллүүн «Линьжихөү Дин, И, Дин Э ах дүү хоёулаа хамт архи ууж халамцаад оморхоглон ёс бусчилнэ. Зарлигийн элч хүрсэн атал Линьжихөү лахайн сууж хөдлөхгүй, Дин и хараан өгүүллүүн, Эрт өдөр Урьд ван чухам миний эзнийг шицзи (суурин залгамжлагч) байгуулна хэмээснийг бялдууч түшмэд хориглон зогсоов. Өдгөө ван өөд болоод өдөр удаагүй атал даруй яс махаас ял асуух нь юун болой хэмээнэ. Дин Э бас хэлэх нь миний эзний ертөнцөд хосгүй сэцэн гэгээнээр болбоос их сууриныг залгамжилваас зохих бөгөөтөл өдгөө харин вангийн суурийг олсонгүй, таны тэндэх түшмэд хэрхэн энэ мэт эрдэмтнийг танихгүй аж хэмээсэнд Линьжихөү нэмээслэж цэргийн ардаар намайг жанчиж гаргав» хэмээв.

Цао Пэй сонсоод их л хилэгнэж Сюй Чүд гурван мянган шилсэн цэрэг өгөөд гал мэт түргэнээр Линьжид одож Цао Жи нарын нэгэн аймаг хүнийг баримтлан ирэгтүн хэмээжээ. Сюй Чү ... хотод орж, шууд яаманд хүрч үзвээс Цао Жи, Дин И, Дин Э нар цөм согтоод унтаж амой.

...Цөмийг хүлээд тэргэнд тээж авчрах Цао Пэйд өргөвөөс урьд Дин И, Дин Э нарыг алуулав.

Дин И-гийн өргөсөн нэр Зэн-ли, Дин Э-гийн өргөсөн нэр Жинли, Пэй жижүн газрын хүмүүс бөгөөд тэр цагийн нэртэй утгач (найрагч) нар бүлгээ. Алагдах үес нь хүмүүс олонтаа хорсов.

Цао Пэйгийн эх Бяньши, Цао Сюний боомилон үхсэнийг сонсоод дотор маш хашран бүхүйд гэнэт бас Цао Жи баригдаад түүний хоршоо Дин и нар алагдав хэмээн сонсч их л сочоод санд мэнд харшид гарч Цао Пэйд учирсугай хэмээн дуудуулсанд Цао Пэй яаран ирэв. Бяньши эхнэр уйлж өгүүллүүн:

— Чиний дүү Цао Жи ер архинд дуртай тул согтсон хойно Ээмий хэлнэ. Лав өвчүүний цаана эрдэм байхдаа эрэмшээд тийнхүү дураар аашилна. Чи нэгэн хэвлийгээс төрснийг бодож, амийг үлдээн өгөх болохул би есөн булгийн доор хүрэвч нүд амар анина.

Цао Пэй өгүүллүүн:

— Хөвгүүн би бас ч түүний эрдмийг их л хайрлах тул юун аюумшиггүй хорлоно. Өнөө түүний омгийг бууруулсугай хэмээх буй заа.

Эх битгий зовогтун гэв.

Бяньши эхнэр нулимсаа арчаар орлоо. Цао Пэй жигүүрийн харшид ороод Цао Жи-г дуудуулах үед Хуа Синь асууруун:

— Мөнөөхөн тайхү Цзи-жяныг (Цао Жигийн өргөсөн нэр) битгий алагтун хэмээн ятгав уу? Цао Пэй «тийм» гэсэнд Хуа Синь:

— Цзи-жянь чадлыг өвөрлөж, мэргэнийг тэвэрсэн тул эцэстээ нуурын доторхи юм бус. Эртнээс арилгахгүй бол хожим эрхгүй зовлон болно хэмээв. Цао Пэй өгүүллүүн:

— Эхийн захиагаас зөрчиж болно уу? Хуа Синь:

- Хүн цөм Цзи-жяныг ам нээмэгц уянга бүтнэ хэмээлцэнэ. Сайд би итгэмжлэхгүй. Ван түүнийг дуудан авчраад, эрдмийг нь тэнсэж үзэгтүн. Хэрэв чадахгүй болбоос даруй алсугай. Чадваас бууруулаад дэлхий дахины бичгийн ардын амыг бөглөсүгэй хэмээсэнд Цао Пэй үгийг дагав.

Удалгүй Цао Жи орж ирээд айн эмээн сөгдөж ял хүлээсэнд Цао Пэй өгүүллүүн:

— Би чам лугаа сэтгэлэг хэдий ах дүү боловч журам нь эзэн сайд хэмээгдэнэ. Чи ямар аюумшиггүй эрдэмд эрэмшиж ёс бусчилна. Урьд эцэг бүхий цагт чи үргэлж утга уянгаар хүнд сайшаагдах бүлгээ. Би чамайг бусдаар бичүүлсэн болов уу хэмээн сэжиглэнэ. Эдүгээ чи долоон алхмын дотор нэгэн шүлэг уншсугай. Үнэхээр чадваас амийг хэлтрүүлнэ. Чадахгүй бол давхар ялаар шийтгэнэ гэв. Цао Жи өгүүллүүн.

— Сэдэв гарган өгөхийг хүснэ.

Тэр цагт харшийн туурганд бэхийн угаар зурсан нэгэн ороодоо зураг өлгөх ажгуу. Түүнд хоёр үхэр хэрмийн доор мөргөлдөөд нэг нь худагт унаж үхжээ. Цао Пэй зургийг зааж:

— Даруй энэ зургаар сэдэв болгосугай. Шүлэгт хоёр үхэр, хэрэм, худаг гэх мэт үгсийг оруулж үл болно хэмээсэнд Цао Жи долоон алхмын эцэст шүлэг бүтээд уншруун;

Хоёр мах нэгэн замаар яваад

Тэргүүнд муруй яс ургажээ.

Хүдгэр уулны дор уулзаад

Гэнэт босч харилцан тулалцав.

Хоёр дайсан цөм хатуугаас айхгүй

Нэгэн мах шороох уурхайд хэвтэв.

Хүчин хүрэхгүй болсон учир бус,

Уур нь бас ч дуусаагүй бүлгээ хэмээжээ.

Цао Пэй, жич олон түшмэд цөм хиртхийв. Цао Пэй:

— Энэ долоон алхын уянга бүтээхийг би мөнхүү удаан хэмээн санана. Чи миний дуун гармагц даруй нэгэн шүлэг уншиж чадна уу?

Цао Жи өгүүллүүн:

-Даруй сэдвийг захитугай.

Цао Пэй өгүүллүүн:

— Би чам лугаа ах дүү болой. Даруй үүнээр сэдэв болгосугай. Бас ч ах дүү хэмээх үсгийг (үгийг) оруулж болохгүй хэмээхүйеэ Цао Жи өчүүхэн ч бодохгүй ам нээмэгц өгүүллүүн:

—Буурцагийг буурцагийн ишээр чанахуйяа

Буурцаг тогооны дотор уйлна утгаа нэгэн үндэслэн ургасан билээ

Буцалгах нь хэрхэн ийм түргэн аж хэмээжээ.

Цао Пэй сонсоод нулимс асгаруулахад эх Бяньши хойт харшаас гарч ирээд «Ах нь хэрхэн дүүгээ энэ мэт цухалдуулна» хэмээсэнд Цао Пэй санд мэнд суудлаас босч зайлаад өгүүллүүн:

— Улсын цаазыг гэж үл болно хэмээгээд Цао Жиг бууруулж Ань сянь хөү болгосон хойно Цао Жи салах ёсоор мөргөөд морь унаж одов.